

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ДОРЖСҮРЭН ОВОГТОЙ
ДОЛГОРСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Зорилтод түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. Гаалийн байгууллагын шударга байдлыг дэвшүүлэх							
1	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	Төсвийн хэмнэлт, хувиар, үүссэн өглөг, авлага, төгрөгөөр,	Гаалийн байгууллагын 2024 оны урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 69.0 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 77.5%-иар буюу 30.3 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Гүйцэтгэл 47.9 тэрбум төгрөг буюу 21.5 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан.	Эхний хагас жилд: 1.Тайлант оны батлагдсан төсвийг оновчтой хуваарилан, зарцуулалтад хяналт тавьж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг бүрэн хангаж ажилласан байна.	Биелэлт: 1. Гаалийн байгууллагын 2025 оны эхний хагас жилийн байдлаарх урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 54.5 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 22%-иар буюу 15.1 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар гүйцэтгэл 44.5 тэрбум төгрөг буюу 10.0 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. Гаалийн байгууллагын батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилахдаа 2024 оны төсвийн гүйцэтгэл, ажиллаж буй орон тоо, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах бусад хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилж, Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй байх чиглэлээр төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ажиллаа. Гаалийн байгууллагын 2025 оны эхний хагас жилийн байдлаарх урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 54.5 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 22%-иар буюу	01.01-06.10	100

					15.1 тэрбум төгрөгөөр буурч батлагдсан. 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар гүйцэтгэл 44.5 тэрбум төгрөг буюу 9.6 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажиллаж байна. Гаалийн байгууллагын батлагдсан төсвийг харьяа гаалийн газар, хороодод хуваарилахдаа 2024 оны төсвийн гүйцэтгэл, ажиллаж буй орон тоо, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах бусад хэрэгцээ шаардлагыг үндэслэн хуваарилж, Төрийн хэмнэлтийн хууль, Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төсвийн зардлыг хэмнэх, өр авлага үүсгэхгүй байх чиглэлээр төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулан ажиллаа. 2025 оны эхний хагас жилийн батлагдсан урсгал үйл ажиллагааны төсвийн 83.2% буюу 44.9 тэрбум төгрөгийг Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ЭМНДШ-ийн зардал, 6.5% буюу 3.5 тэрбум төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.7% буюу 0.4 тэрбум төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 0.4% буюу 0.2 тэрбум төгрөгийг нормативт зардал, 2.2% буюу 1.2 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.3% буюу 0.2 тэрбум төгрөгийг томилолтын зардал, 5% буюу 2.7 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 0.2% буюу 0.1 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.3% буу 0.7 тэрбум төгрөгийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэл байна. 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаарх урсгал үйл ажиллагааны зардлын гүйцэтгэлээр 84.3% буюу 37.5 тэрбум төгрөгийг Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ЭМНДШ-ийн		
--	--	--	--	--	---	--	--

					зардал, 7.2% буюу 3.2 тэрбум төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.8% буюу 0.3 тэрбум төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 0.4% буюу 0.2 тэрбум төгрөгийг нормативт зардал, 1.3% буюу 0.6 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.2% буюу 0.1 тэрбум төгрөгийг томилолтын зардал, 4% буюу 1.8 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 0.1% буюу 0.04 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 1.6% буюу 0.7 тэрбум төгрөгийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэл байна. 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаарх урсгал үйл ажиллагааны зардлын хэмнэлтийн 77.8% буюу 7.5 тэрбум төгрөгийг Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ЭМНДШ-ийн зардал, 3.1% буюу 0.3 тэрбум төгрөгийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, 0.6% буюу 0.06 тэрбум төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 0.2% буюу 0.02 тэрбум төгрөгийг нормативт зардал, 6.4% буюу 0.6 тэрбум төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардал, 0.9% буюу 0.08 тэрбум төгрөгийг томилолтын зардал, 9.9% буюу 0.9 тэрбум төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал, 0.8% буюу 0.07 тэрбум төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 0.3% буюу 0.03 тэрбум төгрөгийг урсгал шилжүүлгийн зардал тус тус эзэл байна. 2. Гаалийн байгууллагын 2025 оны төсвийн төслийн саналд 160.3 тэрбум төгрөгийн саналыг тусган Сангийн яаманд хүргүүлснээс урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 158.9 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ нь өмнөх онтой		
--	--	--	--	--	--	--	--

					харьцуулахад 5.4%-иар буюу 8.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. 3. Туслах үйл ажиллагааны орлогоор 2025 оны эхний хагас жилд 2.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 1.4 тэрбум төгрөг төвлөрүүлж 60.3 хувийн гүйцэтгэлтэй байна. Сангийн сайдын 2025 оны А/36 тоот тушаалаар Сангийн сайдын 2018 оны 253 дугаар тушаалаар баталгдсан журмын 6 болон 7 дугаар хавсралтыг хүчингүй болгосноор гаалийн хилээр нэвтэрч буй иргэд, аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслээс хураадаг ариутгалын хураамжийн авахаа больсон. Хүрсэн түвшин: Гаалийн байгууллагын 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар урсгал төсвийн гүйцэтгэл 81.6% буюу 10.0 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан.		
2	Байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргах, удирдлагыг мэдээллээр хангасан байдал, аудит хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт, үр дүн	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ҮАГазраас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "Өөрчлөлтгүй" санал дүгнэлтийн 3 зөвлөмжийн хамт ирүүлсэн.	Эхний хагас жилд: 1.Байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, Үндэсний аудитын газарт хүргүүлэн хянуулж, "Өөрчлөлтгүй" санал дүгнэлтийг авсан байна. 2.Аудитын байгууллагаас ирүүлсэн	Биелэлт: 1. Гаалийн байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд гаргаж, баталгаажуулан, Үндэсний аудитын газраар шалгуулж Өөрчлөлтгүй санал дүгнэлтийг 2 зөвлөмж, 1 албан шаардлагын хамт ирүүлсэн. /Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн товч үзүүлэлтүүдийг хавсаргав./ 2. Байгууллагын 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн боловсруулж, Сангийн яаманд хүргүүлэн баталгаажуулсан. Мөн байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийгдсэн аудитаар ирүүлсэн 2 зөвлөмж, 1 албан шаардлагын биелэлтийг ханган, заасан хугацаанд тайлагнан ажиллаа. /Тайланг	01.01-06.10	100

				зөрчлийг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, биелэлтийн явцыг тайлагнана.	хавсаргав/ Хүрсэн түвшин: Гаалийн байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас ирүүлсэн Зөвлөмж, Албан шаардлага, актын хүрээнд ГЕГ-ын ХШҮДАГ-тай хамтран ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж, биелэлтийг ҮАГазарт тайлагнан ажилласан.		
3	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	Хэрэгжилт биелэлтээр	2024 онд 26 нээлттэй тендер, 34 харьцуулсан тендер, цахим дэлгүүрээс 9 худалдан авалт, 69 бараа, ажил үйлчилгээг худалдан авахаар төлөвлөн ажиллаж, худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу ил тод нээлттэй цахимаар зохион байгуулан ажилласан бөгөөд худалдан авах ажиллагаатай холбоотой ямар	Эхний хагас жилд: 1.Тайлант хугацаанд төлөвлөсөн худалдан авах ажиллагааг хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулж, өглөг, авлага үүсгэлгүй ажилласан байна.	Биелэлт: Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 11,270.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдэхээр батлагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах тоног төхөөрөмжийн нэр төрөл, тоо хэмжээг ГЕГ-ын Захиргааны зөвлөлийн хуралдааны 2025 оын 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01 дүгээр шийдвэрээр баталгаажуулсан. Уг шийдвэрийн дагуу ГЕГ-ын 2025 оын 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 тушаалаар 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хасвралтаар батлагдсан ГЕГ-ын 2025 онд санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмжийн жагсаалтыг батлуулсан. Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 233 дугаар тогтоолын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэх албан бичгийг худалдан авах тоног төхөөрөмжийн жагсаалт, техникийн үзүүлэлтийн хамт ГЕГ-ын	01.01-06.10	100

			нэгэн өр авлага үүсээгүй болно. Худалдан авах ажиллагааг зөв оновчтой төлөвлөн ажилласнаар хугацаа хоцорч зарлагдсан арга хэмжээ байхгүй бөгөөд тендер ирүүлэгчээс гаргасан гомдлын дагуу хугацаа хойшилж дахин зарлагдсан тендерүүд тайлант ондоо багтан тендер шалгаруулалтыг зохион байгуулж үр дүнг тооцон ажилласан.		2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01/100 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллагааны газраас тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулж дараах аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах зөвлөмжийг ирүүлсэн. Монгол улсын 2025 оны төсвийн тухай хуулиар Гаалийн ерөнхий газрын хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээнд 11,270.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас Төрийн худалдан авах ажиллагааны газраас ирүүлсэн гэрээ байгуулах зөвлөмжийн дагуу 7 төсөл, арга хэмжээний гэрээг хуулийн хугацаанд багтаан 100 хувь байгуулсан. 1 төсөл, арга хэмжээ нь 05 сарын 31-ны дотор гэрээ байгуулах зөвлөмж нь ирээгүй тул 540 сая төгрөгийн төсөв Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу төсвийн хэмнэлтэд тооцогдсон болно. Гаалийн ерөнхий газрын урсгал төсвөөр 2025 онд нээлттэй 5, харьцуулалтын аргаар 3, нийт 8 тендер зарлахаар төлөвлөсөн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна. Мөн ерөнхий гэрээгээр 4 худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гаалийн байгууллагын 2025 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлтийг Сангийн яамны PIMIS программд оруулан ТХААГ-аас зохион байгуулсан тендерийн гүйцэтгэгчтэй байгуулсан 6 компанийн гэрээг баталгаажуулан гүйцэтгэл гаргахад бэлэн болсон. /Тайлант онд зохион байгуулсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дэлгэрэнгүй	
--	--	--	--	--	---	--

					тайланг хавсаргав./ Хүрсэн түвшин: Гаалийн байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийг зохион байгуулах Үнэлгээний хороо байгуулах ГЕГ-ын даргын 2025 оны 8 тушаалыг батлуулж худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.		
4	Албан хаагчдын нийтлэг баталгаа цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал	Хэрэгжилт, биелэлтээр	2024 онд Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлын хүрээнд тус нэгж нь албан хаагчдын хоолны үнийн хөнгөлөлтийг нэмэгдүүлэх, улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажилласан гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх	Эхний хагас жилд: Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлсэн байна.	Биелэлт: 1.Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх: Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор Гаалийн байгууллагын 1580 төрийн тусгай, 492 төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 6%-иар нэмэгдүүлсэн. 2. Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж: Гаалийн ерөнхий газрын даргын тушаалын дагуу Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийн 2025 оны 1-5 дугаар сард эрх нь үүссэн нийт 27 төрийн тусгай албан хаагчдад 513,4 сая төгрөгийг хуваарилж олгосон байна. 3. Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж: Гаалийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрч гарч буй нийт төрийн тусгай-5, төрийн	01.01-06.10	100

		мөнгөн тэтгэмж ийг олгох, нийт албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох, гачигдал гарсан албан хаагчидад хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу мөнгөн тэтгэмж олгох, захиргааны санаачлагаар шилжилт хөдөлгөөнд хамрагдсан албан хаагчдад холбогдох баримтыг үндэслэн нүүлгэлтийн зардал олгох, гаалийн улсын байцаагчийг албан үүргээ хэвийн, аюулгүй явуулах нөхцөл боломжийг хангах үүднээс дүрэмт хувцасны хангалтыг зохион байгуулах, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настангуудын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн		үйлчилгээний-1 албан хаагчдад 143,7 сая төгрөгийн тэтгэмжийг хуваарилж олгосон. 4. Урамшуулал: Засгийн газрын 2011 оны 345 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчдын 2025 оны 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд 2072 албан хаагчдад нийт 2,3 тэрбум төгрөгийг хуваарилж олгосон. /Дэлгэрэнгүй тайланг хавсаргав./ Хүрсэн түвшин: Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлын хүрээнд тус нэгж нь албан хаагчдын хоолны үнийн хөнгөлөлтийг нэмэгдүүлэх, улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажилласан гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж ийг олгох, нийт албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн урамшуулал олгох, гачигдал гарсан албан хаагчидад хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу мөнгөн тэтгэмж олгох, гаалийн улсын байцаагчийг албан үүргээ хэвийн, аюулгүй явуулах нөхцөл боломжийг хангах үүднээс дүрэмт хувцасны хангалтыг зохион байгуулах, хилийн боомтоос гаалийн хяналтын бүс рүү зөөвөрлөх, алслагдмал хилийн боомтуудаас ар гэртээ хүрэх замдаа зам тээврийн осолд өртөх, гэмтэж бэртэх тохиолдлууд их байдаг тул аюулгүй байдлыг нь бүрэн хангаж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж гэнэтийн ослын	
--	--	--	--	--	--

			хүрээнд Ахмадын сангийн хөрөнгөөс ахмадуудад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажилласан.		даатгалд хамруулах, мөн өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настангуудын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх чиглэлийн хүрээнд Ахмадын санг байгуулж, сангийн хөрөнгөөс ахмадуудад дэмжлэг үзүүлэх зэрэг ажлуудыг үр дүнтэй зохион байгуулж ажиллаа. Хүрсэн түвшин: Албан хаагчдын нийтлэг баталгаа цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд бүрдүүлэн ажиллаж байна.		
5	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьсан байдал.	Гэрээний биелэлтийн үнэлгээгээр	Гаалийн ерөнхий газрын төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2024 онд 96%-р дүгнүүлсэн.	Эхний хагас жилд: Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг хангуулах зорилгоор нийт хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, тайлан бүртгэл тооцоог сайжруулан төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг хангуулах чиглэлээр болон үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтыг	Биелэлт: Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Сангийн сайдын 2024 оны 213 дугаар тушаалын дагуу худалдан авсан тээврийн хэрэгслүүдийг ГЕГ-ын даргын 2025 оны А/31 дүгээр тушаалаар Баян-Өлгий аймаг дахь гаалийн газар, Улаанбаатар хот дахь гаалийн газар, Сэлэнгэ аймаг дахь гаалийн газар, Дорнод аймаг дахь гаалийн газар, Хөвсгөл аймаг Ханх дахь гаалийн хороонд тус тус хуваарилсан. Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжүүлсэн “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн хүрээнд Гаалийн ерөнхий газар, Сүхбаатар, Алтанбулаг, Боршоо хилийн боомтуудад нийт 767,8 сая төгрөгийн хөрөнгийг ГЕГ-ын даргын 2025 оны А/32 дугаар тушаалаар бүртгэлд тусгасан. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Сангийн сайдын багцын IX.2.3.1 хуулийн дугаартай “Тоног төхөөрөмж” /Улсын хэмжээнд/ төслийн санхүүжилтээр Замын-Үүд, Гашуунсухайт хилийн боомтуудад суурилуулсан нийт 2,2	01.01-06.10	100

				сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулсан байна.	тэрбум төгрөгийн тоног төхөөрөмжүүдийг ГЕГ-ын даргын 2025 оны А/33 дугаар тушаалаар бүртгэлд тусгасан. Эдийн засаг, хөгжлийн яам, Азийн хөгжлийн банкнаас санхүүжүүлсэн “Эдийн засгийн хамтын ажиллагааны бүс хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Гаалийн автоматжуулсан мэдээллийн систем /cais/-ийг Хилийн удирдлагын нэгдсэн системд холбосон хөгжүүлэлтийн ажлыг ГЕГ-ын даргын 2025 оны А/104 дүгээр тушаалаар Гаалийн ерөнхий газар бүртгэлд тусгасан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны үл хөдлөх хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай 89 дүгээр тогтоолын дагуу ГЕГ-ын даргын 2025 оны А/103 дугаар тушаалаар Сайншанд дахь гаалийн газрын балансад бүртгэлтэй нийт 3,9 тэрбум төгрөгийн үл хөдлөх хөрөнгө, газар эзэмших эрхийг Ханги дахь гаалийн газарт шилжүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гашуунсухайт хилийн боомтын экспорт болон импортын хэсэгт суурилуулсан нийт 11,9 тэрбум төгрөгийн иж бүрдэл хяналтын систем / ачааны автомашин шалгах рентген тоног төхөөрөмж/-ийг ГЕГ-ын даргын 2025 оны А/183 дугаар тушаалаар Гашуунсухайт гаалийн газарт хуваарилсан. ГЕГ-ын даргын 2025 оны А/105, А/182 дугаар тушаалуудаар харьяа гаалийн газар, хороод хооронд нийт 400,0 сая төгрөгийн хөрөнгийг хуваарилсан. Хүрсэн түвшин: Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын балансад худалдан авсан бараа материалыг балансад бүрэн бүртгэж		
--	--	--	--	---	---	--	--

					авсан. ГЕГ-ын ААҮА болон Харьяа гаалийн газар, хороодод шаардлагатай үндсэн хөрөнгө болон бараа материалыг хуваарилан ажилласан.		
6	Төсөв, санхүүгийн шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 онд 2 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан. Суурь үнэлгээ 9 оноогоор үнэлэгдсэн.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	Биелэлт: ЗГ-ын 2009 оны 143-р тогтоол Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн төсвийн ил тод байдал болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар ханган ажиллаа. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг Гаалийн байгууллагын www.customs.gov.mn цахим хуудасны Ил тод байдлын цэс болон шилэн дансны цахим хуудас санхүүгийн мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь нийтэд ил тод байхаар байршуулсан болно. Шил ажиллагааны https://shilen.gov.mn/ сайтад өөрийн нэгжийн хамааралтай мэдээллүүдийг улирал бүр шинэчлэн ОНХА-д хүргүүлэн тус сайтад байршуулан ажиллаж байна. Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийн ил тод нээлттэй байдал 97.63 хувиар үнэлэгдсэн байна. 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт сар бүр 6 мэдээлэл 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт сар бүр 6 мэдээлэл 3. Байгууллагын батлагдсан төсөв жилд нэг удаа 2025.01.10-нд 4. Цалингийн зардлаас бусад таван сая	01.01-06.10	100

					төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ – тухай бүрд нь 32 мэдээлэл 5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ – тухай бүрд нь 48 мэдээлэл 6. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт тухай бүрд нь 6 мэдээлэл 7. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг – тухай бүрд нь 52 мэдээлэл 8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр – тухай бүрд нь 39 мэдээлэл 9. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл – сар бүр 7 удаагийн мэдээлэл 10. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – жил бүр 2025.01.10-нд 11. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт – жил бүр 2025.01.10-нд 12. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл – тухай бүрд нь 8 мэдээлэл 13. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн – Тухай бүрд нь 6 удаагийн мэдээлэл Хүрсэн түвшин:		
--	--	--	--	--	--	--	--

					Хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй. Мэдээллийг иж бүрэн байршуулж ажилласан.		
7	Улсын орлогын барааны хадгалалт, хамгаалалт, шийдвэрлэлтэд хяналт тавих, гаалийн хяналт шалгалтад ашиглагдах маягт, ломбоны хангалтыг зохион байгуулсан байдал	Хэрэгжилт гүйцэтгэлээр	1. УОБ: Гаалийн байгууллагын хэмжээнд: УОБ-ны тайланг 2023 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн. Эхний үлдэгдэл 2015.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2087.0 сая төгрөг байна. 502.5 сая төгрөгийн бараа улсын орлого болгож, 57.6 сая төгрөгийн бараа устгаж, 26.9 сая төгрөгийн бараа худалдан борлуулсан байна. Гаалийн байгууллагын хэмжээнд 6 газар, хороод- /ГЕГ, УБГГ, ЗҮГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ/-д улсын орлого болгосон бараатай байна. 2. Нэг удаагийн троссон ломбо: Харьяа гаалийн газар, хороодын албан хүсэлтийг	Эхний хагас жилд: 1.Харьяа гаалийн газар, хороодын улсын орлогын барааны хөдөлгөөнд бүртгэлээр хяналт тавьж, шийдвэрлэгдээгүй удсан барааны үлдэгдэлгүй байна. 2.Тооцоот хуудас, ломбоны бүртгэл хөтлөлт, зарцуулалтад бүртгэлээр хяналт тавьж орлогын тооцоог баталгаажуулсан байна.	Биелэлт: 1. Гаалийн байгууллагын хэмжээнд улсын орлогын барааны тайланг 2024 оны жилийн эцсийн байдлаар нэгтгэсэн. Эхний үлдэгдэл 2087.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 2832.5 сая төгрөг байна. 1,108.3 сая төгрөгийн бараа улсын орлого болгож, 57.6 сая төгрөгийн бараа устгаж, 26.9 сая төгрөгийн бараа худалдан борлуулсан байна. Тухайн орон нутгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлд 342.5 сая төгрөгийн бараа хүлээлгэн өгч шийдвэрлүүлсэн байна. Шинжилгээнд 4.2 сая төгрөгийн бараа шинжилгээнд өгсөн байна. Гаалийн байгууллагын хэмжээнд 6 газар, хороод- /ГЕГ, УБГГ, ЗҮГГ, СЭГГ, БӨГГ, УВГГ/-д улсын орлого болгосон бараатай байна. БИГГ, УХШИГГ, ЧХОУНБГГ, ДОГГ-ууд орон нутгийн зөвлөлтэйгөө хамтран ажиллаж улсын орлогын барааны үлдэгдэлгүй болсон байна. Гаалийн байгууллагын хэмжээнд улсын орлогын барааны тайланг 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар нэгтгэсэн. Эхний үлдэгдэл 2832.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4058.7 сая төгрөг байна. 1237.7 сая төгрөгийн бараа улсын орлого болгож, 10.7 сая төгрөгийн бараа устгаж, 0.8 сая төгрөгийн бараа тухайн орон нутгийн Засаг даргын дэргэдэх зөвлөлд шилжүүлсэн байна. Гаалийн байгууллагын хэмжээнд 5 газар, хороод- /ГЕГ, УБГГ, ЗҮГГ, СЭГГ, БӨГГ/-д улсын орлого болгосон бараатай байна. 2. Харьяа гаалийн газар, хороодын албан хүсэлтийг үндэслэн нэг удаагийн троссон улаан	01.01-06.10	100

			үндэслэн нэг удаагийн троссон улаан ломбо 785,300 ширхэг, ногоон ломбо 21,000 ширхэгийг тус тус олгож тухай бүр хангалтыг шуурхай зохион байгуулан ажиллалаа.		ломбо 411,000 ширхэг, ногоон ломбо 21,000 ширхэгийг тус тус олгож Үүнд: Нэг удаагийн улаан ломбо олгосон байдал: УБГГ-10,000 ш ЗҮГГ- 20,000 ш СЭГГ-10,000 ш ДОГГ- 70,000 ш БӨГГ-1,000 ш ХОГГ-20,000 ш СШГГ-5,000 ш ДАГГ-2,000 ш ОГГ-2,000 ш УХШИГГ-1,000 ш ГСГГ-200,000 ш БИГГ-20,000 ш ХГГ-50,000 ш Нэг удаагийн ногоон ломбо олгосон байдал: УБГГ-10,000 ш УХШИГГ-1,000 ш 3. 2025 оны эхний хагас жилд гаалийн хяналт шалгалтад шаардлагатай 132.4 мянган төгрөгийн 600 ширхэг шийтгэлийн хуудас маягт- 1, маягт-2, 2,502.5 мянган төгрөгийн 4550 ширхэг экспорт, импортын гэрчилгээ мэдэгдэл шинээр хэвлүүлэн орлогод авсан. ГЕГ-ын дэргэдэх ААҮА болон харьяа гаалийн газар, хороодод 9,305.8 мянган төгрөгийн гаалийн хорио цээрийн хяналтын экспорт, импортын 17 нэр төрлийн 82658 ширхэг гэрчилгээ мэдэгдэл, 2,481.1 сая төгрөгийн 110100 ширхэг зорчигчийн гаалийн мэдүүлгийн хуудас /Монгол, Англи, Орос, Хятад хэлтэй деклараци /, мөн 93.4 мянган төгрөгийн 450 ширхэг шийтгэлийн хуудас тус бүр олгон байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган	
--	--	--	--	--	---	--

					ажиллалаа. Харьяа гаалийн газар, хороодтой 2025 оны 2 дугаар улирлын шийтгэлийн хуудас маягт-1, маягт-2 хуудасны тайлан, хорио цээрийн экспорт импортын гэрчилгээний тайланг нийлж нэгтгэн баталгаажуулсан. /Улсын орлогын бараа болон гаалийн хяналт шалгалтад ашиглагдах маягт, ломбоны хангалтын талаарх дэлгэрэнгүй тайланг хавсаргав. Хүрсэн түвшин: 1. Тухайн орон нутгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл болон Нийслэлийн прокурортой хамтран ажиллаж байна. 2. Нэг удаагийн троссон ломбоны хангалтыг шуурхай зохион байгуулан ажиллалаа. Харьяа гаалийн газар, хороодын албан бичгийг үндэслэн нэг удаагийн ломбоны хангалтыг тухай бүр тасалдал, хомсдол үүсгэлгүй зохион байгуулсан. 3. Нэг тооцоот хуудасны хангалтыг шуурхай зохион байгуулан ажиллалаа. Харьяа гаалийн газар, хороодын албан бичгийг үндэслэн нэг удаагийн ломбоны хангалтыг тухай бүр тасалдал, хомсдол үүсгэлгүй зохион байгуулсан.		
8	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалын хавсралтад заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайланг 5 оноогоор үнэлүүлсэн.	Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалын хавсралтад заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг тайлагнан	Биелэлт: Үндсэн болон нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлт, АО-с төлөх НДШ-ийн зардлууд, Төрийн тусгай албан хаагчийн сэлгэн ажилуулалт болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн тоотой уялдуулан үр дүнгийн урамшуулалын зардал, боомтуудын бүтээн байгуулалттай холбоотой байр ашиглалтын зардлууд, автомашинуудын урсгал засвар, тээвэр, шатахууны зардал, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсэн албан	01.01-06.10	100

				ажилласан байна.	хаагч болон нас барсан албан хаагчийн ар гэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, бичиг хэрэг, улсын мэдээллийн маягт хэвлэх зардал, шуудан холбоо, багаж техник хэрэгсэл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын үйлчилгээ, газрын төлбөр, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах ажилчдын орон сууц, хилийн боомтуудын урсгал засвар, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудын 88 саналыг тооцоо, судалгааг тус тус үндэслэн нийт 11,0 тэрбум төгрөгийг төсвийн хуваарьт 5 удаагийн өөрчлөлт оруулж харьяа газар, хороодод хуваарилан зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна. Хүрсэн түвшин: Гаалийн байгууллага нь 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар 10.0 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.		
9	Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Нэгжийн чиг үүрэгт хамааралтай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг бүрэн хэрэгжүүлж 5 оноогоор үнэлэгдсэн.	Нэгжийн чиг үүрэгт хамааралтай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	Биелэлт: -Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, болон хуульд нийцүүлэн гаргасан алиаа эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан. -Гаалийн байгууллагын урсгал үйл ажиллагааны төсвийн сар улирлын хуваарь болон 1-5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган ажилласан. -Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн	01.01-06.10	100

					23.3-т заасан хугацаандаа 2024 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг ХАСХОМ-ын системд мэдүүлж, байгууллагын ЭБАТ-аар баталгаажуулсан. Хүрсэн түвшин: Хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан.		
10	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, биелэлтээр	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэн оноогоор үнэлэгдсэн. 3	Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажилласан байна.	Биелэлт: -Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор хилийн боомтоос гаалийн хяналтын бүс рүү зөөвөрлөх, алслагдмал хилийн боомтуудаас ар гэртээ хүрэх замдаа зам тээврийн осолд өртөх, гэмтэж бэртэх тохиолдлууд их байдаг тул аюулгүй байдлыг нь бүрэн хангаж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж, нийт 2400 албан хаагчдыг 2025 онд ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛД бүрэн хамруулах зардал болох 300,0 сая төгрөгийг төсөвт тусгасан. -Сүүлийн жилүүдэд боомтын шинэчлэлийн хүрээнд хилийн гаалийн хяналт шалгалтын /ухаалаг гарц, телехяналтын систем, рентген, хар тамхи/ болон лабораторийн тоног төхөөрөмжүүд шинэчлэгдэн орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа хэдий ч байгалийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр гэмтэх, шатах, эвдрэх нөхцөл байнга үүсч байгаа тул ЭД ХӨРӨНГИЙН ДААТГАЛД хамруулах зардал болох 100,0 сая төгрөгийг төсөвт тусгасан. Хүрсэн түвшин: Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан.	01.01-06.10	100
11	Үүрэг даалгавар,	Хэрэгжилт биелэлтээр	Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг	1.Өгөгдсөн үүрэг даалгаврыг цаг	Биелэлт: -Тайлант хугацаанд нийт 47 албан бичиг	01.01-06.10	100

	зөвлөмжийн биелэлт		хугацаанд нь бүрэн биелүүлж 4.5 оноогоор үнэлэгдсэн.	хугацаанд нь бүрэн биелүүлж ажилласан байна. 2.Бусад газар, нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.	боловсруулан илгээж, ГЕГ-ын ЗББНДБ-аас ирсэн явсан дотоод зурвасууд нийт 210 албан бичгийг шийдвэрлэсэн байна. - Авлигатай тэмцэх газрын 2025 оны 03/2734 дугаар албан бичгээр Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/11 дүгээр тушаалаар баталсан “Ашиглалтын гэрээний загвар”-ын “Ашиглагч байгууллагын эрх, үүрэг”-т талбайн ашиглалттай холбоотой тогтмол зардал (түлш, халаалт, гэрэл цахилгаан, цэвэр, бохир ус, цэвэрлэгээ үйлчилгээ)-ний төлбөр тооцоог “Ашиглагч байгууллага” хариуцахаар нэмэлт өөрчлөлтийг тусган хэрэгжүүлэх зөвлөмжийг ирүүлсэн. Уг зөвлөмжийн хүрээнд харьяа гаалийн газар, хороодын өмчлөлийн байранд байрлаж байгаа төсөвт байгууллагуудад ногдох байр ашиглалтын зардлын тооцооллыг гарган Хил хамгаалах ерөнхий газар, Гадаадын иргэн харьяатын газар, Тагнуулын ерөнхий газар, Хилийн боомтын захиргаа, Оюуны өмчийн газарт тус тус хүргүүлж байгууллагынхаа 2026 оны төсөвт тусган хэрэгжүүлж хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлж ажилласан. Хүрсэн түвшин: - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаваруудыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.		
12	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, биелэлтээр	Өмнөх оны үнэлгээ: 4.5	Энхий хагас жилд: 1.Нэгжийн ажлын цаг ашиглалт суурь түвшнээс сайжирсан байна. 2.ГБ-ын хөдөлмөрийн дотоод журмын	Биелэлт: Тус нэгжийн албан хаагчид ажлын цагийн бүртгэлийг нүүр таниулах системээр бүртгүүлж хэвшсэн бөгөөд албан хаагчид ажлын цагаар гадуур ажиллах үед гаалийн захиргаа, дотоод ажлын системээр нэгжийн даргад хүсэлт илгээн хянуулж, Хүний нөөцийн асуудал хариуцсан нэгжээр баталгаажуулалт хийлгэдэг. Тайлант	01.01-06.10	100

				9.3.4-т заасны дагуу “Гаалийн удирдах төв байгууллагын албан хаагч гадуур ажиллах, албан томилолтоор ажиллах, ээлжийн амралтаа эдлэх, чөлөө авах тохиолдолд харьяалах нэгжийн дарга нь Захиргаа, дотоод ажлын систем /CERP/-ийн холбогдох цэсэд хүсэлтийг илгээж, тухайн нэгжийн хүсэлт илгээсэн албан хаагч урьдчилан ээлжийн амралтын хуудас болон чөлөөний хуудсаа ЗУГ-ын даргаар баталгаажуулан, хүлээн авч ААҮА-нд хүлээлгэн өгнө.	хугацаанд СХОГ-ын ажлын цаг ашиглалт 100 хувь, чөлөөтэй, тасалсан цагтай албан хаагч байхгүй. Хүрсэн түвшин: Тайлант хугацаанд нийт албан хаагч ажлын цаг ашиглалт 100 хувь, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй, орон тоо дутуу, ажлын зайлшгүй шаардлагаар албан хаагчид ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй илүү цагаар ажиллаж байна.		
13	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг	Хэрэгжилт биелэлтээр	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжүүлж 9	Эхний хагас жилд: 1.Боомтын асуудал хариуцсан	Биелэлт: Тайлант хугацаанд Хөшигийн хөндий ОУНБ дахь хил хяналтын байгууллагуудын нэгдсэн нэг цэгийн үйлчилгээний төв, Замын-Үүд,	01.01-06.10	100

	үүргийн хэрэгжилт		оноогоор үнэлэгдсэн.	нэгжийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, өөрийн нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан ажилласан байна.	Алтанбулаг, Сүхбаатар, Боршоо, Гашуунсухайт боомтуудын бүтээн байгуулалтын барилгын ажил, боомтуудад шинээр суурилуулах гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн байршил, суурилуулалт, Шивээхүрэн, Булган, Хавирга, Баянхошуу, Сүмбэр, Ханги, Бургастай, Цагааннуур, Ханх, Ульхан боомтуудын өргөтгөл шинэчлэлийн нарийвчилсан зураг төслийн ажил, шаардлагатай гаалийн хяналт шалгалтын тоног төхөөрөмжийн судалгаа, болон хилийн боомтод ажиллах албан хаагчдын амьдрах нөхцөлийг бүрдүүлэх талаар судалгаа хийх, санал боловсруулах ажлыг зохион байгуулахад Боомтын хэлтсийг удирдлага арга зүйгээр ханган ажиллаа. Хүрсэн түвшин: Боомтын асуудал хариуцсан нэгжийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар ханган, өөрийн нэгжийн үйл ажиллагаатай уялдуулан ажилласан.		
--	----------------------	--	-------------------------	--	---	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

..... /Д.ДОЛГОРСҮРЭН/

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

**САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Д.ДОЛГОРСҮРЭНГИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байна.	Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн сургалтад 2025.03.13-06.10 хүртэлх хугацаанд хамрагдан 9 багц кредит цуглуулж Е1711 дугаартай гэрчилгээ авч төгссөн.	03.13-06.10	100
2	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бие дааж уншиж судалсан байна.	Өөрийн чиг үүргийн хүрээнд Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Хяналт шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг уншиж судалж хэрэгжүүлж байна. Мөн Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх бягтлан бодох бүртгэлийн журам”-ыг хэрэгжүүлэн ажилласан.	01.01-06.10	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 /Д.ДОЛГОРСҮРЭН/

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ДОЛГОРСҮРЭНГИЙН 2025 ОНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ	Гүйцэтгэлийн түвшин	Нийт оноо (70 оноо)
1	2	3	4
1	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт		61,7

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Удирдлагын академийн Эрхэлсэн түшмэлийн сургалтад хамрагдах		15
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх		15
Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо:			15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ

Д/д	Үзүүлэлт	Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор)
1.	Хандлага, ёс зүй	13
2.	Удирдан зохион байгуулах	13
3.	Асуудал шийдвэрлэх	13
4.	Манлайлах	13
5.	Багаар ажиллах	13
6.	Харилцаа	13
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)		
7.	Мэргэжлийн ур чадвар 1.	
Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо		13

4. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
-----	---------------------	--------------------------

1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт	61,4
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ	13
4.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт	—
Нийт оноо=		
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо+Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо+Хандлага, ёс зүй, ур чадварын оноо) – Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо		89,4

Үнэлгээ өгсөн:

Гаалийн ерөнхий газрын дарга

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч



Төсвийн шууд захирагч:

..... (Р.Отгонжаргал)
 2025. 06. 10 (огноо)

Нэгжийн дарга:

..... (Д.Долгорсүрэн)
 2025. 06. 10 (огноо)